




Барилга угсралт, их засварын ажил 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.5 их наяд төгрөг болж, 4.4 (97.7%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 104.6 (2.3%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 695.6 (13.4%) тэрбум төгрөгөөр буурахад дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 685.3 (13.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн.



Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эцэст /тэрбум төгрөг/




Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 4.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 403.8 (9.0%) тэрбум төгрөгөөр, төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 287.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 251.3 (46.6%) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагын барилга угсралт, их засварын ажил 48.1 тэрбум төгрөг болж, 30.2 (38.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.




Барилга угсралт, их засварын ажлын 35.2 хувийг орон сууцны барилга, 32.6 хувийг орон сууцны бус барилга, 29.4 хувийг инженерийн барилга, байгууламж, 2.8 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оноос орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 1.8 нэгж хувиар өссөн бол орон сууцны бус барилгын эзлэх хувь 1.5 нэгж хувиар, инженерийн барилга, байгууламжийнх 0.2 нэгж хувиар тус тус буурсан байна.



Барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, жил бүрийн эцэст /тэрбум төгрөг/




БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ /ХУВИАР/






Орон сууцны бус барилга, төрлөөр, жил бүрийн эцэст /тэрбум.төгрөг/



Орон сууцны бус барилгын ажлын гүйцэтгэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 306.5 (17.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд, сургууль, соёлын барилгынх 176.0 (34.4%) тэрбум төгрөгөөр, бусад барилгынх 114.0 (35.5%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 34.7 (38.6%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгынх 20.2 (13.9%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил /тэрбум төгрөг/



Улаанбаатар хотод 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 42.0 хувийг эзэлж, өмнөх оноос 3.9 нэгж хувиар буурсан байна. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 1.4 их наяд төгрөг, Дорноговь аймагт 284.3 тэрбум төгрөг болж, энэ нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 64.3 хувийг эзэлж байна. Эдгээр аймгийн нутаг дэвсгэрт төмөр замын болон газрын тосны үйлдвэрийг дагасан барилга угсралтын ажил эрчимтэй явагдаж байна.